

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

“Түмэн шувуут” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Огноо: 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Цаг: 14:00 -17:55

Хурлын хэлбэр: Биечлэн оролцох /шууд дамжуулалттай/

Хурлын дарга: Ломбын Эрхэмбаяр

Хурлын нарийн бичгийн дарга: Дашцэрэнгийн Наранцэцэг

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн тоо: 160

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо: 162,477,084 ш

Хурлын ирц: 81,24%

Хурлын дарга Л.Эрхэмбаяр: Энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Туушин зочид буудлын Соёмбо танхимд зохион байгуулж байгаа бөгөөд хуралд оролцогсдын оролцоог хангах нээлттэй мэдээлэл өгөх үүднээс **Tovch.mn** цахим хуудсаар шууд дамжуулан хийж байгаа тухай танилцуулав. Мөн хуралд оролцохоор цахимаар бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчдийн гар утсанд 2024 оны 04-р сарын 26-ны өдрөөс эхлэн нэвтрэх код хаягийг санал өгөх кодын хамт илгээсэн болно. Бүртгэлийг www.hural.tumenshuvuut.mn хаягаар цахимаар бүртгэсэн.

Хурлын дарга хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж хурлаар хэлэлцэх асуудал нэг бүрийг хэлэлцсэний дараагаар санал асуух, санал хэлэх, шүүмж хэлэхээр шийдвэрлэв. Энэ жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг өвөрмөц сонирхолтой, олон нийтэд мэдээлэл хүргэх үүднээс зочин илтгэгчдийг урьж оролцуулсан.

ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

1 дэх асуудал: “Түмэн шувуут” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах;

2 дахь асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

3 дахь асуудал: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зардлын төсвийг батлах

ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ

1 ДЭХ АСУУДАЛ:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Ж.Болд

“Түмэн шувуут” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ж.Болд 2023 онд хийж гүйцэтгэсэн ажлууд, оны онцлох үйл явдлууд, тухайн оны санхүүгийн тайлан болон цаашид хийхээр төлөвлөж байгаа зорилтуудынхаа тухай дэлгэрэнгүй мэдээллийг хувьцаа эзэмшигчиддээ танилцуулав. /тайланг хавсаргав./ Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай Төлөөлөн Удирдах Зөвлөл хурлаараа хэлэлцээд дүгнэлт гаргасан бөгөөд уг дүгнэлтийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга А.Бакей нийт хувьцаа эзэмшигчдэд уншиж сонордуулав.

2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:

1. “Түмэн шувуут” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлав.

3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа
200,000,000	162,477,084	200,000,000	162,477,084	200,000,000	162,477,084
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
160,455,839	99,99%	0	0%	8062	0,01%

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,99% зөвшөөрөв.

2 ДАХЬ АСУУДАЛ: Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах видеог дэлгэцээр үзүүлэв. Танхимд хүрэлцэн ирсэн нэр дэвшигчдийн нэрсийг дуудан хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Танилцуулгын гол агуулга: Кумулятив аргаар ердийн болон хараат бус гишүүнийг сонгох зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Мөн цахимаар хэрхэн саналаа өгөх зөвлөмжийг өгөв. Энэ зөвлөмж дээр шинээр журамд орсон өөрчлөлтийг мөн тусгаж заавар өгсөн болно.

1. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:

1. “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгов:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

1. Ломбо овогтой Эрхэмбаяр
2. Балай овогтой Тунгалаг
3. Жигжид овогтой Болд
4. Эрхэмбаяр овогтой Баяржаргал
5. Агипар овогтой Бакей
6. Мэдраа овогтой Болод

2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:

1. Цэдэв овогтой Наран-Учрал
2. Гочоо овогтой Мөнх-Эрдэнэ
3. Өлзийбаяр овогтой Оргил-Эрдэнэ

2. Хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгож ТУЗ-ийн бүрэлдэхүүний талаарх олон нийтэд мэдээлж, шинээр сонгогдсон гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгов.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Д.Наранцэцэг/-д үүрэг болгов.

2. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

Овог нэр	Санал өгсөн эрх	Саналын хувь
Ломбо Эрхэмбаяр	160,771,399	11,13%
Балай Тунгалаг	160,157,685	11,09%
Жигжид Болд	180,553,877	12,5%
Эрхэмбаяр Баяржаргал	180,187,991	12,48%
Агипар Бакей	160,102,302	11,09%
Мэдраа Болод	160,100,356	11,09%

Үүнээс: Л.Эрхэмбаяр, Б.Тунгалаг, Ж.Болд, Б.Баяржаргал, А.Бакей, М.Болод нар сонгогдов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

Овог нэр	Санал өгсөн эрх	Саналын хувь
Гочоо Мөнх-Эрдэнэ	160,243,221	11,1%
Цэдэв Наран-Учрал	160,186,996	11,09%
Өлзийбаяр Оргил-Эрдэнэ	120,056,965	8,31%
Батсуурь Ганбаяр	1,671,802	0,12

Аюуш Ганзориг	110,747	0,01%
Дашрэгзэн Байгалмаа	13,325	0,01%
Батжав Амарсанаа	5,959	0,01%
Хүүхэн Батжаргал	5,500	0,01%
Дамба Ганхүрэл	5,001	0,01%
Энэбиш Баатарцогт	1,276	0,01%
Батаа Баттулга	707	0,01%

Үүнээс Ц.Наран-Учрал, Г.Мөнх-Эрдэнэ, Ө.Оргил-Эрдэнэ нар сонгогдов.

3 ДАХЬ АСУУДАЛ:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Хурлын дарга Л.Эрхэмбаяр

Танилцуулгын гол агуулга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал, зардлын төсөвийг хэмжээг тогтоох тухай хэлэлцэв.

2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр

1. “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллыг хавсралтаар танилцуулав. *(Хавсралтаар: Ердийн болон хараат бус гишүүдийн цалинг улирал бүрийн тогтсон хурал хийж тогтмол 1,500,000 төгрөгийн цалин, хуралд оролцсон байдлаар тооцож ТУЗ-ийн 1 удаагийн хуралд оролцоход гишүүн тус бүр 300,000 төгрөгийн цалин авахаар танилцуулав.)*

2. Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлын санхүүжүүлэлтийг хийж ажиллахаар танилцуулав.

3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа
200,000,000	162,477,084	200,000,000	162,477,084	200,000,000	162,477,084
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
160,458,753	99,98%	246	0,001%	4902	0,019%

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,98% нь зөвшөөрч, 0,001% нь татгалзаж, 0,019% нь түдгэлзэв.

Мөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд “Онч аудит” ХХК-ийн партнер Б.Анхтайван оролцож, хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулсан бөгөөд компаний зүгээс хувьцаа эзэмшигчдэд Ногдол ашиг хуваарилах тухай мэдээллийг хүргэхээс гадна зочин илтгэгч С.Идэр”Хөрөнгөтөн”, А.Идэрбат “Хувьцааны зөв сонголт”, Х.Хатанбаатар “Амжилтанд хүргэх ур чадвар”, Г.Мөнх-Эрдэнэ “Түмэн шувуутын ханш хэзээ сэргэх вэ?”, Л.Эрхэмбаяр “Нууцаа хуваалцъя” сэдвүүдээр сонирхолтой илтгэлүүд тавьсан нь хувьцаа эзэмшигчдэд үр өгөөжтэй байсан ба цаашид энэ хэлбэрээр хурлаа зохион байгуулж байх саналыг хүртэл дэвшүүлж байсан.

АСУУЛТ ХАРИУЛТ:

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ:

Хувьцаа эзэмшигч: Хувьцаагаа халааслах тал дээр ямар үзэл бодолтой байдаг вэ?, ямар тохиолдолд хувьцаагаа халааслах ёстой юм бэ?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Энэ бол их ерөнхий ойлголт юм. Таван богд ХХК ҮЦК-ийн сургалтанд зөндөө явж байгаа. Би та бүхнээс юу хүсч байна гэхээр яг Түмэн шувууттай холбоотой, яг хэлэлцсэн асуудалтай холбоотой асуулт асуувал сайн байна гэж хүсэх байна. **Хувьцаа эзэмшигч:** “Түмэншувуут” 3 санхүүжилт хэд вэ? Хэрхэн шийдвэрлэж байгаа вэ? **Гүйцэтгэх захирал Ж.Болд:** Нийтдээ 35 тэрбум төгрөг төлөвлөж байгаа. Эхний ээлжийн санхүүжилтийг Хүнсний хувьсгалын хүрээнд Голомт банкаар дамжуулан 48 сарын хугацаатай 15 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан байгаа.

Хувьцаа эзэмшигч: ТУЗ -ын хараат бус гишүүнд эмэгтэй гишүүд сонгоё. Тогтвортой хөгжил, оролцоо, жендэр харгалзаж үзэх боломжтой юу?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Хувь хүмүүсийн хэнийг сонгох асуудал дээр бид нөлөөлж бол чадахгүй. Тийм учраас заавал эмэгтэйг сонгоорой гэхээр хэцүү. Гол хөрөнгө оруулсан хүмүүс хэнийг сонгохыг хүсч байна тэрнийг л сонгох дэлхийн жишиг юм даа.

Хувьцаа эзэмшигч: Төвлөрөл 80% гэдэг хувьцаат компаниас ХХК болох боломжтой болжээ. Иймд ХХК болох уу? Төвлөрлийг хэрхэн бууруулах вэ?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Энэ их үнэн хэлсэн байна. Төвлөрөл гэдэг Л.Эрхэмбаяр түүний гэргий, охин гээд ний нуугүй л ярихаас аргагүй. Бид нийлээд 51 ба түүнээс дээшийг эзэмших сонирхолтой. Яагаад гэвэл тахианы аж ахуй мэдэхгүй хэн нэгэн хүнээр удирдуулаад засаглалаа өгвөл маш том эрсдэлтэй. Энэ эрсдэлийг бид бүгдээрээ үүрнэ. Бүгдээрээ хохирно. Тийм учраас мэддэг хүмүүс нь хийж байх ёстой. Хоёрдугаарт бид 51 хувь хүртэл бууруулах сонирхолтой. Гэхдээ 340 төгрөгөөр бол би хэзээ ч зарахгүй. Үүнийг цаашаа бодитойгоор өөр үнэл хүрнэ гэдэг бол дотроо итгэл үнэмшил маш өндөр байдаг. Саяхан манай компанид Монголчуудынхэн бүхний мэддэг 1 компани танай 30 хувийг авья гэсэн. Тэд зах зээлийн ханшаар авья гэсэн. Мэдээж ийм хямд авья гэдэг тэдний зөв. Ийм хямдхан байхад нь би хэрвээ хувьцаагаа зарвал хамгийн тэнэг хүн байхгүй юу. Ийм л байдлаас болоод хувьцааг бол бид лав оройхондоо зарахгүй. Өсөхөөр нь зарвал зарах асуудлыг яахав бодож үзье гэсэн байдалтай байна.

Хувьцаа эзэмшигч: Жижиг хувьцаа эзэмшигчдийн хувийн максимумдаа хэд болгох вэ?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Жижиг ч байна уу, том ч байна уу гэж л хэлье л даа бидний нэгдмэл сонирхолтой хүмүүс хувьцааны нийт төвлөрлийг цаашдаа бууруулах сонирхолтой. Тэр сонирхол маань хувьцааны үнэ цэнээс шалтгаална. Цаг хугацаа орно.

Хувьцаа эзэмшигч: Баруун туруун “Усжуулах” компани Түм-н баланс дээр тусгагдсан эсэх?

Ерөнхий нягтлан бодогч Н.Должинсүрэн: Нэгтгэсэн тайлан дээр тусгагддаг.

Гүйцэтгэх захирал Ж.Болд: “Усжуулах” ХК тусдаа хуулийн этгээд, Баруунтуруунд бүртгэлтэй, манай охин компани. Тэгэхээр тусдаа тайлангаар зохицуулагддаг. “Түмэн шувуут” дээр “Түмэн шувуут” компанийн тайлан, Баруунтуруунд “Усжуулах” ккоманий тайлан, нэгтгэсэн дээр энэ бол тусгагдана. Тэгэхээр нэгтгэсэн санхүүгийн тайлан гэсэн тусдаа баланс тайлан байх ёстой. Нэгтгэсэн санхүүгийн тайланг компаний вэб сайтаас харж болно.

Хувьцаа эзэмшигч: “Өөг өндөг” гээд Ангар захиралын эхлүүлэх гэж байгаа төсөл Түмэн шувуут ХК-н борлуулалтад хэр нөлөөлнө гэж бодож байна? Жижиг төсөл бол биш юм шиг байсан?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Манайд одоо 40 хувь 200-аад сая ш өндөг импортоор орж ирж байна. Түмэн шувуут-3 ашиглалтанд орсоноор 140, 150 саяыг зөвхөн Түмэн шувуут хангана. Цаана нь байгааг манай бусад 10, 20 жил ажилласан аж ахуйнууд байгаа. Тэд хийгээд эхэлсэн. Цаашдаа өндөгний зах зээл дээр өрсөлдөөн бий болно. Тэгэхээр бид одооноос өрсөлдөөнд маш нягт нямбай ажиллах ёстой, ажиллаж байна. Бүтээмжээ нэмэгдүүлэх ёстой, автоматжуулалтыг нэвтрүүлэх ёстой. Аль болох бага хүн ажиллуулж, их бүтээмж хийж байж ноу хау, инноваци шинжлэх ухааны ололтуудыг нэвтрүүлж бид зах зээл дээр өрсөлдөж чадна. Тэрний төлөө ойрын хэдэн жил юу болохыг бид таамаглаж байгаа. Тэр дагуугаа алхам алхмаар бэлтгэлээ хангаж байгаа.

Хувьцаа эзэмшигч: Ногдол ашгаа хэзээ тараах вэ?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: 2024 оны 04 сарын 09 бүртгэлийн өдөр байсан. Ногдол ашгаа 04 сарын 30-ны өдөр тараана.

Хувьцаа эзэмшигч: Дараагийн жилүүдэд “Түмэн шувуут” компанийн үнэлгээ юунаас хамаарч өсөх вэ, хамгийн чухал өсөлтийг тэтгэх хүчин зүйл юу вэ?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Малын тэжээлийн орон зай бас 1 юм явах гээд байгаа. Монголын мал аж ахуйн эрхлэлтэнд өөрчлөлт орно. Тэр бол жоохон хугацаа орно. Гэхдээ бидэнд энэ дээр маш том боломж гарч ирнэ. Ялангуяа манай компанид хөдөө аж ахуй тэр дундаа мал аж ахуй, газар тариалан малын тэжээлийн талаар бид аль ч компанитай өрсөлдөж чадах туршлага хүний нөөц байгаа. Тийм учраас өндөгний бизнес ингээд ханалт руу орно. Харин тэрний хажуугаар малын тэжээллийн бизнес ид цэцэглэх болно. Ийм учраас өсөлт бол байнга тогтвортой явна.

Хувьцаа эзэмшигч: ТУЗ-ын гишүүдийг сонгох санал хураалтыг нээлттэй явуулбал итгэл нэмэгдэнэ ээ. Нээлттэй явуулдаг болмоор байна?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Одоо нээлттэй явж байгаа гэж ойлгож байгаа. Бүх компаниуд цахимаар санал хураалт явж байгаа. Хийхээс өөр аргагүй. Цахимаар санал хураахад бид хэдэн төгрөгөөр хөлсөлдөг вэ. Зөвхөн энэ санал хураалтыг л явуулахад “Маркет инфо” гэж компанитай хамтран ажиллаж байна. Маркет инфогоос хүн байвал хариулт өгнө үү. Зарим юмыг би хариулж чадахгүй. Их зөв асуулт асуулаа гэж ойлгож байна.

“Си Эм Си консалтинг” ХХК-ийн захирал Б.Ганболд: Манай программ бол хөндлөнгийн программ. 2018 оноос хойш бид энэ программаа хөрөнгийн зах зээлд хэрэгжүүлж байгаа. Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох байгууллагад бүртгэлтэй. Манайх 1 биш олон компанид өнгөрсөн хугацаанд хурал хийж ирсэн. Одоо ч бас хийж байгаа. Энэ дээр бид компанийг ямар нэгэн байдлаар удирдах ч гэдэг юм уу, албан тушаалтны нөлөөнд ордоггүй. Хувь хүний зүгээс баталгаа гаргахад нээлттэй байна. Үүнтэй холбоотой ямар нэгэн маргаан гарах юм бол хариуцлагыг хүлээхэд бэлэн байна. Итгэлтэй байж болно.

Хувьцаа эзэмшигч: Аюулгүй байдал эрсдэлийн ямар менежмент байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: Энэ бол зайлшгүй асуудаг асуултын нэг. Шувууны аж ахуй гэхээр өндөр эрсдэлтэй гэж ойлгодог. Энэ бол үнэн. Эрсдэлтэй. Шувууны аж ахуй олон улсад өргөн дэлгэр энэ хэлбэрээр ажиллаж байдаг. Шувууны аж ахуйг эрсдэлгүй эрхлэх арга замууд бас байгаа. Түүнийг бид нар үйл ажиллагаандаа нэвтрүүлж байгаа. Дэгдээхий байхаас нь эхлүүлээд бид бүх шувуундаа толгой дараалан 8 төрлийн өвчний эсрэг вакциныг бид хийдэг. Ингэснээр шувуу тухайн өвчнөөс сэргийлэх ач холбогдолтой. Ингэж дархлаатай болдог. Мөн мал эмнэлэг ариун цэврийн дүрэм журам стандартуудыг маш сайн баримталдаг. Нэг заалны ажилтан нөгөө зааланд ордоггүй. Дамжин өнгөрдөггүй жишээтэй. Түмэн шувуут-1, Түмэн шувуут-2 гэж тусдаа байгааг анзаарч байгаа байх. Бид бүх өндөгөө 1 сагсанд хийхийг хүсэхгүй байгаа гэсэн үг. Газар талбай нь боломжтой ч гэсэн тусдаа байгаа. Тэжээлийн үйлдвэр нь ч гэсэн тусдаа байгаа. Бүгд тус тусдаа байршилтай. Энэ нь эрсдэлийг тооцож ажиллаж байгаа гэсэн үг юм. Эцэст нь бид Мандал даатгалтай хамтарч ажилладаг. Өчигдөрхөн бид үл хөдлөх хөрөнгийн даатгалын гэрээг шинэчилж байгуулсан. Тэрний өмнө мал амьтны буюу тахианы даатгал хийгдсэн. Шувуу болон бүх үл хөдлөх хөрөнгөө даатгуулж байна гэсэн үг. Ингэж бид аль болох эрсдэлээс сэргийлж ажиллаж байгаа юм. Дээрээс нь эрсдэлийн удирдлагын менежментийг хэрэгжүүлээд төлөвлөгөө гаргаад ажиллаж байна. Аль болох олон эрсдлүүдийг урьдчилж харж удирдахын төлөө ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигч: Үндсэн хөрөнгө болон зээлийн харьцаа ямар байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: Хөрөнгө зээл эздийн өмч 46 тэрбум байна. Нийт хөрөнгө бол 68 тэрбум байна. Урт хугацааны зээл 9 тэрбум. Өөрсдийн эргэлтийн хөрөнгө борлуулалтын орлогоороо энэ зээллийг бүрэн төлөх боломжтой. Авч байгаа зээлүүд хүү болон хугацааны хувьд нэн таатай нөхцөлтэй. Үүнийг заавал авч ашиглах нь үйлдвэрлэлийн эдийн засгийн ач холбогдолтой. Бүх банктай маш сайн хамтарч ажилладаг. Зээлийн хамгийн бага нөхцөлийг авч чаддаг. Жилийн хамгийн дээд хүү бол 8 хувьтай, зарим нь 6 хувьтай байгаа.

60 сарын хугацаатай гэх мэт байна. Зөвхөн 1 зээл жилийн 15,3 хувийн хүүтэй байгаа. Энэ бол зээлийн шугам байгаа. Бусад нь 8 хувь, 6 хувийн зээл байгаа. Азийн хөгжлийн банк, Засгийн Газрын хөнгөлөлттэй зээл байгаа. Эдгээр зээлүүдийг авч үйл ажиллагаагаа өргөжүүлж байна.

Хувьцаа эзэмшигч: Аудитын газраас асуумаар байна. Танай аудитын газар өөр хувьцаат компаниудад хир аудит хийж байв. Хийж байсан бол тэр хувьцаат компаниудтай харьцуулахад бид нарын этгээд байгаа энэ компаний үйл ажиллагаа тайлан хир зэрэг явдаг вэ?

Аудитын партнер Б.Анхтайван. : Манай компаний хувьд Монголын томоохон хувьцаат компаниудад аудит хийдэг. Өнгөрсөн хугацаанд бид Говь ХК, Сүү ХК, одоогоор Газар шим ХК, Түмэн шувуут ХК-иудад аудит хийж байна. Зөвхөн Монголын хөрөнгийн бирж гэлтгүй Олон Улсын биржүүд дээр байгаа Монголд үйл ажиллагаа явуулдаг маш олон компаниуд бид үйлчилгээ үзүүлдэг. Ер нь бол Олон Улсын туршлагатай үндэсний компани байгаа. “Түмэн шувуут” ХК-ийг тусгайлан ярих юм бол голлох хувьцаа эзэмшигчид хоорондоо ямар нэгэн ижил гүйлгээ бол хийгддэггүй. Та бүхэн мэдэж байгаа байх Монголын хувьцаат компаниудын том эзэд өөрсдөө компанитайгаа гүйлгээнүүд хийдэг. Гэтэл “Түмэн шувуут” ХК-д ийм асуудал байдаггүй. Тэгэхээр бүртгэл санхүү дээр ямар нэгэн асуудал гарсан эсвэл буруу илэрхийлэгдсэн зүйл гараагүй. Тэгэхээр та бүхэн энэ санхүүгийн тайланд итгэлтэй байж болно.

Хувьцаа эзэмшигч: Ногдол ашгийн мөнгөө аль дансанд авах вэ?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: Ногдол ашгийг брокерын компаниас лавлах ёстой. Бид нар УЦТХТ-өөр дамжуулаад таны харилцах данс байршиж байгаа данс руу мөнгөө шилжүүлнэ.

Үүгээр асуулт хариултын хэсэг өндөрлөв.

Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийг ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцууллаа.

Хурлын дарга Л.Эрхэмбаяр Хуралд оролцогсдод талархал илэрхийлснээр 17:55 цагт хурал өндөрлөв.

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА :

Л.ЭРХЭМБАЯР

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Д.НАРАНЦЭЦЭГ

